

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2025/016/НА-СТА-ТТЗ

ТӨВ АЙМГИЙН АРГАЛАНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН 2024 ОНЫ
САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Б.Нямсүрэн

Утас: 70272248 Цахим хаяг: nyamsuren@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

АДДС. 03.21 № 01/2026
танай _____-ны № _____-т

ТӨВ АЙМГИЙН АРГАЛАНТ СУМЫН
ЗАСАГ ДАРГА Я.ЭНХБААТАР ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Төв аймгийн Аргалант сумын Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Төв аймгийн Аргалант сумын Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Орон нутгийн хөгжлийн сангаар хийгдэх нийт 351,898.1 мянган төгрөгийн төсөвтэй нийт 5 ажил үйлчилгээнээс ТӨААРСЗДТГ/20240202020 тендерийн дугаартай мал угаалга, мод услахад ашиглах машиныг 48,000.0 мянган төгрөгөөр хүлээн авч ажилласан байна. Малчдын дунд цахим худаг гаргах, Төв суурин газар ногоон байгууламжтай болох, Гудамж талбайн өнгө үзэмжийг засаж сайжруулах ажилд тендер зарласан боловч оролцогч байхгүйгээс шалтгаалж төсөвлөгдсөн ажил бүрэн хийгдээгүй болно. Орон нутгийн хөгжлийн сангийн гүйцэтгэл 14.0 хувьтай зарцуулагдсан байна.

Аудитын гол асуудал

Орон нутгийн давсан орлогоор хийгдэх ажлаас хөрөнгө оруулалтын ажил болох төв зам дагуух гэрэлтүүлгийн ажил 60,000.0 мянган төгрөгөөр, сургуулийн дотуур байрны цонх-20,000.0 мянган төгрөгөөр, ЗДТГ-н тавилга эд хогшил 13,000.0 мянган төгрөгөөр, ЗДТГ-ын тоног төхөөрөмж 12,000.0 мянган төгрөгөөр тус тус хөрөнгө оруулалтууд хийгдсэн байна.

Аймгийн хөрөнгө оруулалт буюу эрх шилжүүлэлтээр Эрүүл мэндийн төвийн сангийн засвар үйлчилгээнд 100,000.0 мянган төгрөгийн төсөвтэй ажил хийгдэхээр төсөвлөгдөж 97,001.7 мянган төгрөгийн засвар үйлчилгээ хийгдэж ажлыг бүрэн хүлээн авч ажилласан байна.

412505001

Бусад асуудлын хэсэг

Тус сумын 2024 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөний хүрээнд 7 хөтөлбөр, 53 арга хэмжээг хэрэгжүүлж 82,5 хувьтай дүгнэгдсэн байна. Хөтөлбөр арга хэмжээнд зориулан зарцуулахаар төлөвлөсөн төсвийн гүйцэтгэл 83,0 хувь байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,220,331,588.17	1,515,226,522.19
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	604,825,106.49	889,220,512.61
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	604,825,106.49	889,220,512.61
31210	Төгрөг	604,825,106.49	889,220,512.61
33	АВЛАГА	498,844,110.36	480,620,087.40
33500	Бусад авлага	451,062,011.00	426,378,840.15
35	БАРАА МАТЕРИАЛ	116,662,371.32	145,385,922.18
35100	Түүхий эд материал	19,162,489.24	21,330,030.00
35400	Хангамжийн материал	93,999,882.08	120,555,892.18
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,450,632,321.11	2,624,096,044.23
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,450,632,321.11	2,624,096,044.23
39200	Биет хөрөнгө	1,797,946,009.92	1,965,002,877.44
39300	Биет бус хөрөнгө	652,686,311.19	659,093,166.79
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,670,963,909.28	4,139,322,566.42
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	11,046,096.49	148,675.14
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	11,046,096.49	148,675.14
41300	Өглөг	11,046,096.49	148,675.14
41360	Бусад өглөг	11,046,096.49	148,675.14
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,659,917,812.79	4,139,173,891.28
51	Засгийн газрын хувь оролцоо	3,659,917,812.79	4,139,173,891.28
51200	Хуримтлагдсан үр дүн	2,131,700,802.92	2,610,956,881.41
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	142,471,799.68	142,471,799.68
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,670,963,909.28	4,139,322,566.42

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,807,774,664.22	2,307,331,826.38
11	ТАТВАРЫН ОРЛОГО	630,719,566.52	942,168,885.64
110	Орлогын албан татвар	444,530,748.52	668,490,433.45
1100	Хувь хүний орлогын албан татвар	461,530,748.52	668,490,433.45
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-17,000,000.00	0
113	Хөрөнгийн албан татвар	101,721,625.00	133,639,770.19
118	Бусад татвар, төлбөр, хураамж	84,467,193.00	140,038,682.00
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	7,341,193.00	6,973,392.00
1181	Газрын төлбөр	77,126,000.00	133,065,290.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	199,720,175.57	530,897,763.24
120	Нийтлэг татварын бус орлого	199,720,175.57	530,897,763.24
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	87,583,729.41	128,952,217.47
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,977,334,922.13	834,265,177.50
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	161,587,512.90	265,838,277.50
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,795,286,769.23	524,328,900.00
1330	Төсвийн захирагчдаас	20,460,640.00	44,098,000.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,573,165,303.25	1,830,849,470.89
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,448,091,019.25	1,726,845,752.99
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,243,551,086.79	1,647,443,351.07
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	423,140,885.52	678,070,208.34
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	55,977,203.75	84,090,465.44
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	89,836,237.77	420,677,671.47
2104	Хангамж, бараа материалын зардал	41,257,925.76	50,812,715.00
2105	Нормативт зардал	64,753,249.80	103,476,457.44
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,474,109.70	12,722,000.00
2107	Томилолт, зочны зардал	5,748,400.00	6,422,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,777,246.90	5,158,362.21
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	552,585,827.59	286,013,471.17
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,204,539,932.46	79,402,401.92
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,990,000.00	34,467,134.58
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,202,549,932.46	44,935,267.34
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	125,074,284.00	104,003,717.90
2200	Дотоод эх үүсвэрээр	125,074,284.00	104,003,717.90
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	234,609,360.97	476,482,355.49
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	854,500.00	782,000.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	233,754,860.97	475,700,355.49

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,849,515,928.25	2,159,271,118.38
11	ТАТВАРЫН ОРЛОГО	630,719,566.52	942,168,885.64
110	Орлогын албан татвар	444,530,748.52	668,490,433.45
1100	Хувь хүний орлогын албан татвар	461,530,748.52	668,490,433.45
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-17,000,000.00	0
113	Хөрөнгийн албан татвар	101,721,625.00	133,639,770.19
118	Бусад татвар, төлбөр, хураамж	84,467,193.00	140,038,682.00
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	7,341,193.00	6,973,392.00
1181	Газрын төлбөр	77,126,000.00	133,065,290.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	241,461,439.60	382,837,055.24
120	Нийтлэг татварын бус орлого	241,461,439.60	382,837,055.24
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	151,551,479.00	176,814,917.47
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,977,334,922.13	834,265,177.50
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	161,587,512.90	265,838,277.50
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,795,286,769.23	524,328,900.00
1330	Төсвийн захирагчдаас	20,460,640.00	44,098,000.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,308,438,717.00	1,598,374,864.26
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,308,438,717.00	1,598,374,864.26
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,103,898,784.54	1,517,789,566.62
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	425,678,992.47	677,253,564.89
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	53,432,103.35	84,198,249.61
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	89,423,668.00	422,040,241.24
2104	Хангамж, бараа материалын зардал	17,071,203.00	30,743,885.00
2105	Нормативт зардал	57,850,104.00	127,220,854.38
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,350,000.00	19,403,050.00
2107	Томилолт, зочны зардал	5,748,400.00	6,422,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,879,753.90	9,303,575.21
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	444,464,559.82	141,204,146.29
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,204,539,932.46	80,585,297.64
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,990,000.00	35,650,030.30
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,202,549,932.46	44,935,267.34
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	541,077,211.25	560,896,254.12
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	237,933,880.70	275,718,848.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	237,933,880.70	275,718,848.00
2200	Дотоод эх үүсвэрээр	237,933,880.70	275,718,848.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-237,933,880.70	-275,718,848.00
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-161,094,500.00	-782,000.00
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	161,094,500.00	782,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	142,048,830.55	284,395,406.12
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	462,776,275.94	604,825,106.49
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	604,825,106.49	889,220,512.61

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,385,745,210.19	142,471,799.68	1,907,704,549.94	3,435,921,559.81
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	-9,758,607.99	-9,758,607.99
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,385,745,210.19	142,471,799.68	1,897,945,941.95	3,426,162,951.82
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	233,754,860.97	233,754,860.97
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,385,745,210.19	142,471,799.68	2,131,700,802.92	3,659,917,812.79
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,385,745,210.19	142,471,799.68	2,131,700,802.92	3,659,917,812.79
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	3,555,723.00	3,555,723.00
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,385,745,210.19	142,471,799.68	2,135,256,525.92	3,663,473,535.79
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	475,700,355.49	475,700,355.49
20	2024 оны 6-р сарын 30-наарх үлдэгдэл	1,385,745,210.19	142,471,799.68	2,610,956,881.41	4,139,173,891.28

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

Залруулагдаагүй нийт 16,445.4 мянган төгрөгийн зөрчлөөс 16,445.4 мянган төгрөгийн материаллаг зөрчил нь урьдчилан тогтоосон материаллаг байдлын түвшнээс 13,036.2 мянган төгрөгөөр бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Санхүүгийн тайлангийн аудитаар төлбөрийн акт өгөгдөөгүй.

5.2 Албан шаардлага

Санхүүгийн тайлангийн аудитаар албан шаардлага өгөгдөөгүй.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Орлогын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тус байгууллага тайлант онд Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын батлагдсан төлөвлөгөө 1,043,797.6 мянган төгрөг, гүйцэтгэлээр 1,255,857.3 мянган төгрөг төвлөрсөн ба 25 нэр төрлийн орлогоос 4 нэр төрлийн орлого 16,445.4 мянган төгрөгөөр тасарсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-д “Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр жигд ханган биелүүлэх.

2. Шилэн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тус байгууллага нь Шилэн дансанд мэдээлбэл зохих 157 мэдээллийг мэдээлэхээс 10 мэдээлэл хугацаа хоцроосон байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д “Шилэн дансны зарчим”-ын 4.1.3-д “Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэсэн болон санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны мэдээллийг хугацаанд нь үнэн зөв, бүрэн оруулах.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг 2025 оны 04 дугаар сарын 25-ны дотор, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 10 -ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ЗДТГ	11	425,082.5	2	1,376.5	3	8,204.6	6	415,501.4
Хоршоо хөгжүүлэх сан	2	88,310.3					2	88,310.3
Эргэлтийн эмийн сан	2	12,118.9	1	3,230.0	1	8,888.9		
ИТХ	3	8,805.9					3	8,805.9
Засаг дарга	2	16,445.4					2	16,445.4
Дүн	20	550,763.0	3	4,606.5	4	17,093.5	7	529,063.0

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	1		1					
2	Засаг даргын тамгын газар	1	1				1		
3	Хоршоо хөгжүүлэх сан	1		1					
4	Эмийн эргэлтийн сан	1		1					
5	Орон нутгийн хөгжлийн сан	1		1					
	НИЙТ	5	1	4			1		

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn